



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянбулаг сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/3/СТА-ТТЗ

Баянхонгор
2019 он
Цахим хуудас: www.audit.mn

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор: Г.Ганчимэг
Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 5 |
| 2.1. | Оршил | 5 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 6 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 7 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... | 8 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 8 |
| 2.8. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 8 |
| 2.8.1 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар | 9 |
| 2.8.2 | Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар | 9 |
| 2.9. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.10. | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 9 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл | 10 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.13. | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: | 10 |
| 2.14 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 11 |
| 3 | Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 12 |

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 2/163

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Р.ЖАМЪЯНДОРЖ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519312

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Бөмбөгөр сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem.

Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Р.Жамъяндорж-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 21-нээс 2019 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 03 дүгээр сарын 05-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянбулаг сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянбулаг сумын Засаг дарга нь "Төв Азийн өндөрлөг Баянбулаг хайрханаа шүтэж, онгон байгалиа хадгалан, оюуны чадамж бүхий ахмад үеэсээ суралцан, хүний хөгжлийг хангаж уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлсэн дэд бүтцэд тулгуурлан, зах зээлд өрсөлдөхүйц нутгийн шилдэг бүтээгдэхүүнтэй хангайн бүсийн тэргүүлэх сум болно". гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянбулаг сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг хууль тогтоомжид нийцүүлэн, ард иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх.

Баянбулаг сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгжийн 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянбулаг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр | | | | | | |
|---|-----------------------|------------------------|-------------|----------------|---------------------|----------------------|
| № | Байгууллагын ангилал | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрлэсэн | Итгэл үзүүлсэн | Гэрээгээр хийлгэсэн | Аудитад хамрагдаагүй |
| 1 | Төсвийн шууд захирагч | 3 | 3 | - | 2 | - |
| | Дүн | 3 | 3 | - | 2 | - |

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянбулаг сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянбулаг сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянбулаг сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Баянбулаг сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянбулаг сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,054,144.6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 20,541.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Баянбулаг сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 3570,0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч, 3570,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2277,2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь Э.Нандинбилэгт олгосон урьдчилгаанаас 500,0 мянган төгрөг суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон

Асуудал : Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч нь 3070,3 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй авлага үүсгэсэн байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон

Асуудал 3: Аудитаар Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь 2018 онд шинээр авсан цахилгаан тогоо, усны сав зэрэг 270,0 мянган төгрөгийн хөрөнгийг зарлага гаргасан.

Асуудал 4: Аудитаар Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь 8 хүнд 1735,2 мянган төгрөгийг цалинг илүү олгосон, 28,7 мянган төгрөгийн ндш-ын өглөг, ХХОАТ-т илүү төлсөн 251,1 мянган төгрөг, ҮЭ-ийн татвар 113,3 мянган төгрөгийг тус тус авлага өглөгөөр бүртгээгүй, “Хайрхан фарм” ХХК-д төлөх 149,9 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй.

Шийдэл: 3, 4, дэх алдааг тус тус залруулсан

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянбулаг сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1486370,5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1408520,8 мянган төгрөг буюу 94,7 хувьтай байгаа нь төсөвт байгууллагууд 25049,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, СХС-ийн үлдэгдэл 63195,2 мянга, ОНХС-ын үлдэгдэл 33818,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 35000,0 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 136262,2 мянган төгрөгийн орлого төвлөрч 101262,2 мянган төгрөг буюу 256,8 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ нь ан агнах зөвшөөрлийн төлбөр 90000,0 мянга, торгуулийн орлого 9188,4 мянга төсөвт байгууллагуудын өөрийн орлого 4070,0 мянган төгрөгөөр давуулж биелүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянбулаг сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Шилэн дансны хуулийн заасан өөрт хамаарах 18 төрлийн мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж аваагүй байна.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд Харин эрхлэх асуудлын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5847,5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

| № | Байгууллагын ангилал | Илрүүлэлт | | | | | | Мянган төгрөг | |
|-----|----------------------|-----------|--------|-------|--------|----------|--------|---------------|--------|
| | | Зөрчил | | Алдаа | | Бүгд дүн | | Залруулга | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ТТЗ | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | ТШЗ | 2 | 3570,3 | 3 | 2277,2 | 5 | 5847,5 | 3 | 2277,2 |
| Дүн | | 2 | 3570,3 | 3 | 2277,2 | 5 | 5847,5 | 3 | 2277,2 |

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Мянган төгрөг

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

| № | Байгууллагын ангилал | Залруулаагүй алдаа, зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах санал | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | | |
|---|----------------------|----------------------------|--------|---------------|--------|-----------------|-----|---------|-----|----------------------------|-----|--|-----|-----|-----|
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ТТЗ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| 2 | ТШЗ | 2 | 3570,3 | 2 | 3570,3 | - | - | - | - | - | - | - | - | | |
| | Дүн | 2 | 3570,3 | 2 | 3570,3 | - | - | - | - | - | - | - | - | | |

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

| № | Байгууллагын ангилал | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | | | | |
|---|----------------------|----------------------------------|----------------|-------|----------------------------------|-----|
| | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | Дүн |
| 1 | ТШЗ | 5 | - | - | - | 5 |
| | Дүн | 5 | - | - | - | 5 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 343,383,213.25 | 445,862,379.47 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 52,618,634.17 | 187,512,877.79 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 52,618,634.17 | 187,512,877.79 |
| 3121 | Төгрөг | 52,618,634.17 | 187,512,877.79 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 52,618,634.17 | 187,512,877.79 |
| 33 | АВЛАГА | 186,140,871.00 | 143,981,226.10 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 563,236.00 | 2,347,867.68 |
| 335 | Бусад авлага | 1,787,458.00 | 3,496,477.32 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 250,000.00 | 417,442.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,537,458.00 | 3,079,035.32 |
| 336 | Зээлийн авлага | 183,790,177.00 | 138,136,881.10 |
| 3361 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 183,790,177.00 | 138,136,881.10 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 183,790,177.00 | 138,136,881.10 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 103,531,608.08 | 113,276,175.58 |
| 351 | Түүхий эд материал | 28,686,814.00 | 28,686,814.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 28,686,814.00 | 28,686,814.00 |
| 354 | Хангамжийн материал | 73,495,794.08 | 83,240,361.58 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,594,020.00 | 1,740,220.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,495,738.00 | 21,740,830.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,174,150.00 | 3,580,350.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,093,667.00 | 1,301,470.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 43,138,219.08 | 54,877,491.58 |
| 35600 | Мал амьтад | 1,349,000.00 | 1,349,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 1,092,100.00 | 1,092,100.00 |
| 36600 | Бусад нөөц | 1,092,100.00 | 1,092,100.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,015,051,491.65 | 3,522,144,465.52 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,015,051,491.65 | 3,522,144,465.52 |
| 392 | Биет хөрөнгө | 3,015,057,429.05 | 3,474,687,902.92 |

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,324,994,748.00 | 3,347,244,975.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (694,738,788.65) | (261,615,289.51) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 175,962,496.00 | 166,751,496.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (85,333,559.85) | (88,517,933.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 505,703,019.86 | 537,212,755.86 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (395,306,736.22) | (420,761,162.36) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 189,150,291.83 | 202,405,901.43 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (136,949,749.40) | (154,023,937.03) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 931,620.00 | 931,620.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 129,308,126.00 | 145,738,126.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (25,255,145.72) | (28,477,556.37) |
| 39217 | Ном | 26,591,107.20 | 27,798,907.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | (5,937.40) | 47,456,562.60 |
| 39301 | Програм хангамж | 2,880,000.00 | 2,880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,885,937.40) | (2,885,937.40) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 47,462,500.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>3,358,434,704.90</u> | <u>3,968,006,844.99</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>1,294,360.00</u> | <u>350,108.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,294,360.00 | 350,108.00 |
| 413 | Өглөг | 1,294,360.00 | 350,108.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 944,504.00 | 156,576.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 103,306.00 | 159,052.00 |
| 4136 | Бусад өглөг | 246,550.00 | 34,480.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 46,550.00 | 34,480.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>3,357,140,344.90</u> | <u>3,967,656,736.99</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,357,140,344.90 | 3,967,656,736.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,510,929,668.81 | 1,558,392,168.81 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,510,929,668.81 | 1,558,392,168.81 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,434,611,862.05 | 1,532,783,523.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 248,128,656.32 | 1,434,611,862.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,186,483,205.73 | 98,171,661.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 411,598,814.04 | 876,481,044.79 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>3,358,434,704.90</u> | <u>3,968,006,844.99</u> |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/ |
|-------------|---|-------------------------|-----------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,131,280,939.96 | 1,766,528,007.82 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 32,172,620.00 | 71,868,641.00 |
| 110 | Орлогын албан татвар | 8,468,210.00 | 5,601,617.00 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 8,468,210.00 | 5,601,617.00 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 8,468,210.00 | 5,601,617.00 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,100,000.00 | 2,190,000.00 |
| 113002 | Бууны албан татвар | 2,100,000.00 | 2,190,000.00 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 21,604,410.00 | 64,077,024.00 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 1,756,410.00 | 1,504,200.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,456,410.00 | 1,404,200.00 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 300,000.00 | 100,000.00 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 19,200,000.00 | 60,900,000.00 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 19,200,000.00 | 60,900,000.00 |
| 1183 | Бусад татвар | 648,000.00 | 1,672,824.00 |
| 118301 | Бусад татвар | 348,000.00 | 1,372,824.00 |
| 118304 | Нохойны албан татвар | 300,000.00 | 300,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,395,886,584.42 | 222,458,233.82 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,395,886,584.42 | 222,458,233.82 |
| 120002 | Хүүгийн орлого | 4,700,427.42 | 18,688,454.15 |
| 120003 | Торгуулийн орлого | 1,180,350.00 | 2,308,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,390,005,807.00 | 201,461,779.67 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 61,514,188.00 | 4,389,777.57 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,900,000.00 | 200,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,325,591,619.00 | 196,872,002.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,703,221,735.54 | 1,472,201,133.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,039,632,827.27 | 1,032,944,000.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,165,127.27 | - |

Баянбулаг сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 1,038,467,700.00 | 1,032,944,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,038,467,700.00 | 1,032,944,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 18,466,968.00 | 63,031,172.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,466,968.00 | 63,031,172.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 638,600,985.27 | 363,307,900.00 |
